

2

“ УУЛ УУРХАЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОРЧНЫ ҮНЭЛГЭЭ”

Н.Болор

Оршил

Байгалийн нөөц баялаг их гэж тооцогддог хөгжиж буй эдийн засаг бүхий Монгол улс нь бүс нутагтаа уул уурхайн гол цэг болохоор тэмүүлж байгаа билээ. 2000 оны эхнээс либераль эрх зүйн орчин болон дэлхийн түүхий эдийн зах зээлийн тааламжтай байдал зэргийн ачаар гадаадын хайгуулын хөрөнгө оруулалтыг нилээд их хэмжээгээр татсан. Үүний үр дүнд сүүлийн хэдэн жилийн турш Монголын уул уурхайн салбар жил бүр тогтмол 8-12 хувиар өсч, эдийн засагт чухал ач холбогдолтой салбар болоод байна. Ердөө 2002-2007 онд нийт экспортын орлого дахь хувь нь 20 пунктээр өсч 80 хувьд хүрч, уул уурхайн салбарын ДНБ-д эзлэх хувь 3 дахин нэмэгдсэн юм.

Metals Economics Group-ийн тайланд 2004 болон 2006 онууд дах Монголын хайгуулын ажлын зардал нийт дэлхийн хайгуулын зардлын 4% байна гэж тэмдэглэсэн нь Монгол нь хайгуулын зардлын хэмжээгээр дэлхийн эхний аравт багтах улс болжээ. Гадаадын хөрөнгөөр хийгдсэн хайгуулын зардал сүүлийн 6 жилд огцом өсч 2005-2006 онуудад 200 тэрбум төгрөгт (180 сая ам.доллар) хүрч өссөн байна.

Гэвч сүүлийн 2 жилд гарсан уул уурхайн салбарын хууль эрх зүйн гол өөрчлөлтүүдээс болж тухайлбал “стратегийн ач холбогдол бүхий орд” гэсэн ойлголтын анх удаа орж ирсэн болон мөн уул уурхайн салбарын алт болон зэсийн баяжмалын орлогоос ихээхэн хэмжээгээр авах татвар (Гэнэтийн ашгийн татвар)-ын хууль гаргаснаас болж салбарын хувьд нилээд уналт 2007 онд ажиглагдсан. Урьд өмнө гарч байгаагүй үргэлжилсэн түүхий эдийн үнийн өсөлт нь мэдлэг мэдээлэл хомс олон нийтийн үндсэрхэг үзэл болон нөөц баялагийг эзэрхэх гэсэн улс төрчдийн национализмыг сэргээсэн билээ. Үүний үр дүнд уул

уурхайн хөрөнгө оруулагчдын дунд тодорхойгүй байдлыг бий болгож хайгуулын ажлын зардлыг 2005 оны түвшин хүртэл нь бууруулсан.

Монголын уул уурхайн салбар нь өнөөг хүртэл тогтворгүй болон явцгүй хуулийн орчныг сайжруулах, уул уурхайн хөрөнгө оруулалтын тааламжтай орчныг бий болгогч бусад тодорхойлогч хүчин зүйлсийн (уул уурхайн татвар, засаглалын чанар болон үр ашигт байдал, дэд бүтцийн болон чадварлаг боловсон хүчний хөгжил) чанарыг дээшлүүлэх том шалгууртай нүүр тулгарсаар байна.

Уул уурхайн хөрөнгө оруулалтын орчны үнэлгээ нь бодлого боловсруулагчдад уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын орчныг сайжруулахад түүнчлэн тус салбар дахь боломжит хөрөнгө оруулагчид хаашаа хөрөнгө оруулахаа шийдэхэд чухал ач холбогдолтой юм. Уул уурхайн хөрөнгө оруулалтын орчны хамгийн анхны үнэлгээ нь Монголын уул уурхайн болон уул уурхайтай холбоотой бизнес эрхлэгчид болон хөрөнгө оруулагчдын дунд зохиогчийн санаачлагаар анх 2008 онд хийгдэж байсан.

Дараагийн үнэлгээний судалгаа нь 2009 оны 9-10 сарын хооронд 2008 оныхтой адил аргачлалаар хийгдсэн. Уг судалгааны гол зорилго нь Монголын уул уурхайн бизнесийн орчны талаарх уул уурхайн хөрөнгө оруулагчдын санаа бодол болон ойлголтод тулгуурласан үнэлгээг гарган харуулах явдал юм. Уул уурхайн хөрөнгө оруулалтын орчныг үнэлэхэд дараах үзүүлэлтүүдийг уул уурхай болон түүнтэй холбоотой бизнес эрхлэгчдээр үнэлүүлдэг. Үүнд: Нийт эдийн засгийн болон улс төрийн төлөв байдал, институтуудын чадавхи мөн засгийн газрын үр бүтээлтэй байдал, дэд бүтцийн болон хөдөлмөрийн зах зээлийн хөгжил, уул уурхайн татварын ерөнхий түвшин, байгаль орчны зохицуулалтуудын нарийн байдал, орон нутгийн иргэдийн харилцаа, аюулгүй байдал зэрэг ордог. Уг үнэлгээнүүдэд тулгуурлан бид “Уул уурхайн хөрөнгө оруулалтын орчны ихдекс буюу “МІС Индекс” нэртэй уул уурхайн хөрөнгө оруулалтын орчны ерөнхий индексийг гаргасан.

МІС ерөнхий индексийн хамгийн их утга нь 1 байдаг бөгөөд Монголын уул уурхайн салбарынх өнгөрсөн жилийнхээс (0.35) бага зэрэг өсч 0.41 –д хүрсэн байна. Ерөнхий индексийг бүрдүүлдэг туслах үзүүлэлтүүдийн (дээр дурьдагдсан) зэрэглэлээс харвал эдийн засаг дах засгийн газрын хэт оролцоо, хөдөлмөрийн\чадварлаг боловсон хүчний мөн дэд бүтцийн (харилцаа холбоог оруулахгүйгээр) хөгжил, хуулийн даган мөрдөлт зэрэг нь ахицтай сайжруулалт хэрэгтэй байгаа хэсэг гэж үзэж байна. Эдгээр үзүүлэлтүүдийн үнэлгээний утгууд нь хамгийн бага түвшинд буюу 0.27-0.33-ын хооронд байна. Орон нутгийн иргэдийн шахалт дарамт, уул уурхайн эрх зүйн зохицуулалтын орчны найдваргүй, тогтворгүй байдал нь уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын орчныг сайжруулахад анхаарах ёстой дараагийн асуудлууд болж байна.

Аргачлал

Уул уурхайн хөрөнгө оруулалтын орчныг үнэлэх шалгуурыг тогтоох олон судалгаа байдаг. Хөрөнгө оруулагчдын хөрөнгө оруулах эсэхээ шийддэг шалгуурт үндэслэн Отго (2007), Фрейзэр Иститут (2008), Бэр Долбер Групп (2008) нарын гаргасан судалгаанаас бид шалгуур үзүүлэлтүүдийн цогцыг бүрдүүлэн Монголын уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын орчны үнэлгээг хийсэн болно.

Монголын уул уурхай, эрдэс баялагийн салбар дах хөрөнгө оруулалтын орчныг дээр гаргасан шалгуураар үнэлэх энэхүү хоёрдох жилийн анкет судалгааг бид 2009 оны 9, 10-р саруудад зохион байгуулан явууллаа. Анкетийн асуулгуудыг Монгол дах уул уурхайн болон уул уурхайтай холбоотой бизнес эрхлэгчид, хөрөнгө оруулагчдаас уул уурхайн хөрөнгө оруулалтын орчны үнэлгээг авахаар боловсруулж загварчилсан. Дараах 15 шалгуур үзүүлэлтүүд нь Монголын уул уурхайн хөрөнгө оруулалтын орчныг үнэлэхэд ашиглагдсан болно.

- (1) макро-эдийн засгийн орчин
- (2) улс төрийн орчин
- (3) уул уурхайн эрх зүйн орчны тогтвортой болон найдвартай байдал
- (4) уул уурхайн татваруудын өрсөлдөх байдал
- (5) ажиллах хүчний хөгжил
- (6) дэд бүтцийн хөгжил: Зам
- (7) дэд бүтцийн хөгжил: Цахилгаан эрчим хүч
- (8) дэд бүтцийн хөгжил: Харилцаа, холбоо
- (9) геологийн тоо мэдээллийн чанар
- (10) засаглалын чанар болон үр бүтээлтэй байдал
- (11) эдийн засаг дахь засгийн газрын оролцоо
- (12) хуулийн сахилт даган мөрдөлт
- (13) байгаль орчны зохицуулалтууд
- (14) аюулгүй байдал
- (15) орон нутгийн иргэдийн харилцаа

Уул уурхайн салбарт шууд болон шууд бусаар үйл ажиллагаа явуулдаг нийт 88 компани, байгуулгууд энэ жилийн уг судалгаанд оролцсон бөгөөд үүнээс 55 хувь нь хайгуулын болон уул уурхайн бизнесийг (үндсэн бизнес) дангаар нь болон давхардуулан хийдэг, 34 хувь нь үндсэн бизнесд төрөл бүрийн үйлчилгээ үзүүлдэг, үлдсэн хэсэг нь засгийн газрын болон олон нийтийн байгуулгууд мөн судалгааны байгууллагууд болно. Түүврийн хэмжээг 2008 онтой харьцуулахад 2009 онд 70 гаруй хувиар өсгөсөн (2008 оны үнэлгээний судалгаанд зөвхөн 52 компани, байгуулгууд оролцсон).

Асуулганд оролцогчдын 41 хувь нь бүгд гадаадын хөрөнгө оруулалтай компаниуд (2008 оны судалгааны 56 хувь нь байсан), 33 хувь Монголын 100 хувийн хувийн өмчит компаниуд болон 17 хувь нь гадаадын болон хамтарсан

үйлдвэрүүд байсан болно. Ажилчдын тоогоор нь авч үзвэл 100 хүртэлх ажилтчинтай буюу жижиг дунд аж ахуйн нэгжүүдийн ангилалд 73 хувь, үлдсэн хэсэг нь 100-аас дээш ажилчин ажиллуулдаг буюу том компаниуд орсон. Асуулганд оролцогчдын гуравны нэгээс доош хэсэг хайгуулын ажил хийж гүйцэтгэж байга учраас үйл ажиллагааны орлогогүй гэсэн бол 50 тэрбум төгрөгөөс (ойролцоогоор 40 орчим сая ам.доллар) доош үйл ажиллагааны орлоготой компаниуд 44 хувийг эзэлж байсан.

Уул уурхайн хөрөнгө оруулалтын тойм

Либераль уул уурхайн хууль эрх зүй болон дэлхийн түүхий эдийн зах зээлийн тааламжтай байдал зэргийн эерэг нөлөөгөөр Монголын уул уурхай, эрдэс баялагийн салбар гадаадын болон дотоодын хөрөнгө оруулалтыг тодорхой хэмжээгээр татаад байна.

Монгол дах хайгуулын зардал нь дэлхийн нийт хайгуулын зардлын 4 хувийг эзэлж Монгол улс нь уул уурхайн хайгуулын ажлаар дэлхийд эхний 10-т орж байгааг Металын Эдийн Засгийн Групп 2004 болон 2006 онуудын тайландаа тусгасан байдаг. Сүүлийн 6 жилд ихэвчлэн гадаадын хөрөнгөөр хийгдсэн хайгуулын зардал огцом өссөн. Доорх Зураг 2-т 2005-2006 онуудад уг зардал 200 гаруй тэрбум төгрөг (180 сая Америк доллар)-т хүрч хоёр дахин нэмэгдсэн болохыг харуулж байна.

Эрдэс баялагийн голлох хуулиудад огцом өөрчлөлтүүд орсноос Монголын уул уурхайн салбар дах хөрөнгө оруулалт 2007 оноос эхлэх ихээхэн хэмжээгээр буурч эхлээд байна. Тухайлбал: “стратегийн ач холбогдол бүхий орд” нэртэй гарч ирсэн ойлголт, “Эрдэс баялагийн хууль”-д шинээр нэмж оруулсан “стратегийн орд” дахь төрийн оролцоо, алт болон зэсийн баяжмалын орлогоос ихээхэн хэмжээгээр авах болсон татвар (Гэнэтийн ашгийн татвар) зэргээс болж 2007 онд уул уурхайн салбарын хөрөнгө оруулалт огцом буурсан болох нь ажиглагдаад байна. Урьд тохиолдож байгаагүйгээр өнөөг хүртэл үргэлжилж буй түүхий эдийн өсөлт нь мэдлэг мэдээлэл хомс олон нийт болон эзэрхэг үзэлтэй улс төрийн националист санаа бодолыг сэргээж байна. Иймээс бодлого боловсруулагчид уул уурхайн хөрөнгө оруулагчдын дунд эрх зүйн тодорхойгүй байдлыг үүсгэж энэ нь хөрөнгө оруулалтыг 2005 оны түвшинд хүртэл бууруулаад байгаа юм.

Эрдэс баялагийн хөрөнгө оруулалтан дах сонирхолыг Монголын өмнөд говь дах Айвенхогийн их хэмжээний зэс-алтны төсөл дэвэргэх болсон. Уг төслийг даган Канад, Австралийн нилээд нэр хүндтэй “аваргууд” болон “залуу” компаниуд хошуурцгаасан билээ. Айвенхо Майнз Монголиа алт-зэсний төсөлдөө 108.1 тэрбум төгрөг (91.6 сая Америк доллар) зарцуулсан бөгөөд 2007 онд энэ хэмжээ эрс багасч 9 орчим тэрбум төгрөг (7.6 сая Америк доллар) болж

буурсан нь Монгол дах хайгуулын зардлын хөрөнгө оруулалтын гол уналтын шалтгаан болсон болсон байна.

Дэлхийн нийтийн санхүүгийн хямралаас болоод түүхий эдийн үнэ огцом унаж, 2008 болон 2009 онуудад нийт дэлхийн уул уурхай хайгуулын хөрөнгө оруулалтыг бууруулахад хүргэсэн. Гэвч Монголд байдал бага зэрэг өөр байна. 2000 оноос хойш Монголын өмнөд хэсэгт хийгдсэн дэлхийн хэмжээний зэс-алтны төслийн эхлэл болон Монголын Засгийн газар, Айвенхо-Рио Тинто консорциум хоёрын хооронд хийгдсэн хөрөнгө оруулалтын гэрээ нь Монголын уул уурхайн салбарт хувийн хөрөнгө оруулалтыг ахин татан дэмжиж эхлээд байна.

Сүүлийн 2 жилд үргэлжилсэн хууль эрх зүйн тогтворгүй орчинд Монголын уул уурхай, эрдэс баялагийн салбар дах тэдний хөрөнгө оруулалт хэрхэн өөрчлөгдснийг уул уурхай болон уул уурхайтай холбоотой бизнес эрхлэгчидээс бид асуухад:

Хүснэгт 1. Уул уурхайн хөрөнгө оруулалтын өөрчлөлтүүд

	2008	2009
	Судалгаа	Судалгаа
Өссөн	50%	43%
Буурсан	34%	29%
Өөрчлөгдөөгүй	16%	28%
Нийт	100%	100%

Хүснэгт 1-д, хөрөнгө оруулалтаа өсгөсөн гэж асуулганд оролцогчид 2008 онд 50 хувь байсан бол 2009 онд 43 хувь болж буурсан байхад мөн хөрөнгө оруулалтаа бууруулсан гэсэн оролцогчид 2009 онд 2008 оныхоос 5 пунктээр буурсан байна.

1. Эдийн засгийн болон улс төрийн нөхцөл байдал

1990-ээд оны эхнээс Монгол улс нь зах зээлд суурилсан эдийн засагт шилжиж эхлээд бараг 20 жилийн нүүрийг үзэж байна. Өдийг хүрэхэд олон гайхалтай үр дүнд хүрсэн нь өндөр зохион байгуулалттай банкны систем, харилцаа холбооны салбар болон тодорхой хийгдсэн хөрөнгө оруулалтын үүднээс барилга, уул уурхайн салбар хурдацтай хөгжсөн зэрэг болно. Гэвч шилжилтийн өмнө сайжруулах анхаарч үзэх ихээхэн орон зай байсаар байна. Тухайлбал зуун хувь улсын мэдэл болон хяналтанд байдаг эрчим хүчний салбар нь 2000 оны эхээрх салбар дах бүтцийн өөрчлөлтийг эс тооцвол дампуурлын ирмэгт хүрээд байна. Засгийн газрын эдийн засаг дахь оролцоо (ДНБ-ний хувиар) мэдэгдэхүйц өндөр болсон, сүүлийн хэдэн жилд өсөх хандлага ажиглагдаж байгаа нь засаглалын үр ашиггүй байдал болон зарим талаар авилгалын хэмжээг ч ихэсгэж байна. Түүхий эдийн үнийн хөөрөгдөлийн үе дэх Эрдэс баялагийн татвараар гэнэт орж ирсэн орлогод үндэслээд өнгөрсөн хэдхэн жилд засгийн газрын зардал урьд өмнө байгаагүй өндөр түвшинээр өсч, энэ нь шилжилт эхэлснээс хойш хүрч

байгаагүй түвшинд хэрэглээний үнийн индексийг хүргэхэд тодорхой хэмжээгээр нөлөөлсөн нь дамжиггүй юм.

Гадаад худалдааны эргэлт нь ДНБ-ээс 100 хувь давдаг Монголын эдийн засаг нь дэлхий дэх хамгийн нээлттэй эдийн засгийн нэгд тооцогддог бөгөөд дэлхий нийтийн санхүү эдийн засгийн хямралд илт өртсөн. Энэхүү судалгаа нь эдийн засгийн уналтын үед хийгдсэн болно. Бид уул уурхайн салбарын хөрөнгө оруулагчдаас нилээд ерөнхийгээр нийт эдийн засгийн байдал сүүлийн хэдэн жилд хэрхэн өөрчлөгдсөн талаар асуусан. Дэлхий нийтийн эдийн засгийн хямрал хэдийнээ эхэлсэн явдал тэдний асуултанд зарим хүрээнд нөлөөлсөн байж болох юм.

2008 онд судалгаанд оролцогчдын гуравны хоёроос илүү хэсэг нь Монголын эдийн засгийн байдал муу байна гэж үзсэн бол 20 хүрэхгүй хувь нь сайжирсан гэж үзжээ. 2009 онд байдал эрс өөрчлөгдөж уул уурхайн хөрөнгө оруулагчдын дөрөвний нэгд хүрэхгүй хувь сөрөг саналтай байхад хагасаас илүү хэсэг нь эдийн засаг сайжирч байна гэж дүгнэсэн байна. Цааш нь бид уул уурхайн хөрөнгө оруулагчдаас эдийн засгийн байдал өөрчлөгдөх (сайжрах эсвэл дордох) нь тэдний цаашдын хөрөнгө оруулалтанд хэрхэн нөлөөлөхийг хэлж өгөхийг хүссэн болно.

Судалгаанд оролцогчдын эдийн засгийн өөрчлөлт тэдний ирээдүйн хөрөнгө оруулалтанд сөрөг нөлөөлдөг гэж үздэг хэсэг 17 хувиар буурсан бол, эерэг нөлөөлдөг гэж үздэг хэсэг 5 хувиар өссөн байна.

Зах зээлийн эдийн засагт засгийн оролцоо байх эсэх талаар эсвэл хувийн хөрөнгө оруулалтын татдаг болон өрсөлдөөнийг тодорхойлдог бизнесийн орчинд засгийн газар нөлөөлөх эсэх талаар олон янзын санал бодлууд байдаг. Зах зээлийн эдийн засагт шилжиж буй Монголын хувьд эдийн засаг дах засгийн газрын оролцоо захиргаадалтын үеийнхээс бага байх ёстой хэдий ч Монгол дах бизнес эрхлэгчид эдийн засаг дах засгийн газрын оролцооны талаар байнга гомдоллож байгаа бөгөөд энэ нь нөөцийн ашиглалтын үр ашигтай болон өрсөлдөөний талаасаа эдийн засгийн орчныг нилээд дордуулж байгаа юм. Эдгээр тайлбарыг батлах нотолгоонууд олон байна. Тухайлбал хэдийгээр эдийн засгийн реформын хөтөлбөрт эдийн засагт гүйцэтгэх засгийн газрын үүргийг бага байхаар тусгасан боловч ДНБ-д эзлэх засгийн газрын зардал нь 1990-ээд оны дунд үеэс байнга өссөөр байна. 1990 онд засгийн газрын хувь (ДНБ-д эзлэх хувь) 30 хүрэхгүй хувьтай байсан бол харамсалтай өнөөдөр аль хэдийнээ 40 гаруй хувьд хүрсэн байна.

Бид уул уурхайн салбарын хөрөнгө оруулагчид болон бусад уул уурхайтай холбоотой үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагуудыг эдийн засаг дах засгийн газрын оролцооны өнөөгийн түвшинийг хэрхэн үнэлж байгаа талаар судалхад

судалгаанд оролцогчдын засгийн газрын оролцоо их байна гэж үздэг хэсэг өссөн байхад, засгийн газрын оролцоо боломжийн гэж үздэг хэсэг 2 дахин өссөн буюу 2008 оноос 2009 онд 20 хувьд хүрсэн байна. Ерөнхийдөө, уул уурхайн хөрөнгө оруулагчдын дийлэнх хэсэг өдийг хүртэл тус улс дах засгийн газрын оролцоо их байна гэж үзсээр байна.

Монгол улс дах улс төрийн нөхцөл байдал ямар байна вэ? Улс төрийн орчин болон үүний тогтвортой байдал нь уул уурхай, эрдэс баялагийн салбарын төдийгүй бусад бизнесийн салбарын хувийн хөрөнгө оруулалтын хувьд чухал хүчин зүйлд тооцогддог. Монголын улс төрийн талаарх хөрөнгө оруулагчдын өнөөгийн үнэлгээг мөн бид судалгаандаа оруулсан. Энэ жилийн судалгаанаас нэг гайхалтай үр дүн гарсан нь Монголын улс төрийн талаарх хөрөнгө оруулагчдын үнэлгээ мэдэгдэхүйц дээшилсэн явдал юм.

Өнгөрсөн жил судалгаанд оролцогчдын бараг 40 орчим хувь нь Монголын өнөөгийн улс төрийн байдал муудсан учраас хөрөнгө оруулалт хийхэд тохиромжгүй гэж байжээ. 2009 оны хувьд уг хувь огцом буурч, Монгол дах улс төрийн орчныг сайжирч байна гэж үзэх хэсэг 3 илүүтэй дахин өсчээ. Гэвч улс төрийн орчныг өөрчлөгдөөгүй гэж үзэх хэсэг 40 гаруй хувьтай байсаар байгаа буюу тодорхой ахицтай өөрчлөгдсөнгүй. Бид мөн хөрөнгө оруулагчдаас өнөөгийн улс төрийн байдал тэдний цаашдын хөрөнгө оруулалтанд хэрхэн нөлөөлөх талаар ямар ойлголт, таамаглалтай байгаа талаар нь асуусан.

Улс төрийн орчны талаарх уул уурхайн хөрөнгө оруулагчдын үнэлгээ мэдэгдэхүйц дээшилсэн тул, тэдний ирээдүйн хөрөнгө оруулалтын боломжит нөлөөллийн тухай ойлголт нь сөрөг хэсгээс эерэг хэсэгт шилжсэн байсан. 2008 онд ирээдүйн хөрөнгө оруулалтанд нь сөрөг нөлөөлнө гэж үзсэн судалгааны оролцогчид нь хагасаас илүү байсан бол энэ хэсэг нь нилээд бага түвшинд (21 хувь) хүртэл буурсан. Нийт оролцогчдын дөнгөж аравны нэг илүүтэй хэсэг нь эерэг нөлөөлнө гэж байсан бол энэ хувь огцом өсч 2009 онд 35 хувьд хүрчээ.

2. Институтууд болон институтын чанар

Нөөц баялаг ихтэй эдийн засаг нь нөөц баялаг ядуу эдийн засгаас удаан өсдөг хандлага нь статистикийн хувьд батлагдсан байдаг. Энэ нөөц болон хөгжил хоёрын хоорондох урвуу хамаарлыг “баялагийн хараал” гэж нэрлэдэг. Гэхдээ нөөц баялаг ихтэй улс болгонд ийм “хараал”-д хүрдэггүй байна. Хэрвээ нөөц баялаг ихтэй улс дах институтууд болон засгийн газар нь хангалттай сайн, нээлттэй биш бол “баялагийн хараал”-д өртөх магадлал нилээд өндөр байдаг болохыг олон судалгаа харуулж байна. Эдийн засгийн хөгжлийн нэг чухал хүчин зүйлд институтын чанарыг оруулж авч үздэг. Сайн институт гэж юу вэ? Институтын чанарыг юу тодорхойлдог вэ?

Институтын чанарыг тодорхойлох олох янзын тодорхойлолт байдаг. Зарим хэсэг нь хараат бус шүүхийн тогтолцоо, засаглалын үр ашигтай байдал болон авилгалын түвшинг авч үздэг бол мөн бас эдийн засгийн эрх чөлөөний индексэд тулгуурладаг байна. 1996 оноос хойш гаргаж байгаа Дэлхийн Банкны Засаглалын Индекс нь маш өргөн ашиглагдаж дурьдагддаг нэг үзүүлэлт юм. Дэлхийн Банкны Засаглалын Индексийг улс төрийн тогтвортой байдал, засгийн газрын нээлттэй илт тод байдал, хуулийн зохицуулалт, зохицуулалтын чанар, хариуцлагын дуу хоолой болон авилгалын хяналт гэсэн бүлэг үзүүлэлтүүдэд үндэслэн тооцдог.

Дэлхийн Банкны Засаглалын үзүүлэлтүүдээс Монгол дах институт болон засгийн газрын чанар муудаж байгааг харж болно. Ялангуяа 6-н үзүүлэлтийн 3 нь болох “засгийн газрын үр ашигт байдал”, “хуулийн даган мөрдөлт”, “авилгалын хяналт” зэрэг нь мэдэгдэхүйц түвшинд муу байна. Тухайлбал, 2007 оны Дэлхийн Банкны Засаглалын Индикаторуудаар бол Монголын дундаж оноо (6-н үзүүлэлтийн дундаж) өмнөх оны мөн оноотой харьцуулахад 3.5 нэгжээр буурсан байна. Илүү нарийвчилбал Монгол улсын засгийн газрын үр ашигт байдлын оноо 2006 онд 36.5 буюу 2007 оны 26.5 оноо нь нилээд бага буюу 10 нэгжээр огцом унажээ. Засгийн газрын үр ашигт байдлын индексээр Монгол 2006 онд 212 орноос 133-т жагсаж байсан бол 2007 онд 156-д орж ухарчээ. “Хуулийн сахилт” болон “авилгалын хяналт” гэсэн үзүүлэлтүүдийн оноо 10-12 нэгжээр 2006 оноос хойш буурсан дүнтэй байна.

Бид уул уурхайн салбар дах хувийн хөрөнгө оруулалтанд хуулийн зохицуулалт болон институтын чанар үр ашигт байдал хэрхэн нөлөөлдөг талаарх санаа бодлыг нь Монголд үйл ажиллагаа явуулж уул уурхайн хөрөнгө оруулагчдаас асуухад өнгөрсөн жил асуулганд оролцогчдын 10 тутмын 9 нь хуулийн хэрэгжилт болон хяналт, зохицуулалтуудад ихээхэн тааламжгүй гэж мэдэгдсэн бөгөөд энэхүү уул уурхай, эрдэс баялагийн салбар дах хөрөнгө оруулалтыг шахаж дарамталдаг гэсэн хэсэг нь их болон өндөр гэсэн 2 түвшинд байна. Гэвч энэ жил энэхүү хэсэг өчүүхэн бага хувиар (90 хувиас 83 хувьд хүрч) буурч тус салбар дах хувийн хөрөнгө оруулалтыг Монголын хуулийн зохицуулалт дэмждэг гэж үзсэн хэсэг багахан хувиар өссөн дүнтэй байна.

Хөрөнгө оруулалт дах институтын чанар болон үр ашигт байдлын нөлөөллийг үнэлэх тусгай асуултуудыг энэ жил асуулганд оролцогчдоос асуусан. Өмнөх жил судалгаанд оролцогчдын бараг 90 орчим хувь нь өнөөгийн институтын үр ашигт болон чанарын байдал сэтгэл хангалуун бус байдаг буюу тэд уг салбар дах хувийн хөрөнгө оруулалтыг дэмжихгүй байна гэж үздэг байсан. Гэвч уг хэсэг энэ жил 67 хувьд хүрсэн буюу институтын (засгийн газрын) чанарыг муу байна гэх хөрөнгө оруулагчидын үнэлгээний хувь тодорхой дүнгээр буурчээ. Өөрөөр хэлбэл, тус салбар дах хувийн хөрөнгө оруулалтыг уул уурхайтай

холбоотой институтууд дэмждэг гэх судалгаанд оролцогчдын хувь өссөн болох нь ажиглагдаж байна.

2006 оныг хүртэл уул уурхай, эрдэс баялагийн салбар дах Монголын хууль болон зохицуулалтын орчинг хамгийн тохиромжтой гэж үздэг байсан буюу гадаадын хөрөнгө оруулалтыг ихээхэн хэмжээгээр уг салбар нь татаад байсан. Жил бүр хийгддэг Фрейзерийн Институтын Уул уурхайн Судалгаа нь дэлхий нийт дэх уул уурхайн боломжит хөрөнгө оруулагчдад нэгэн чухал хөтөч болдог бөгөөд 2005 онд Монгол улс нь уул уурхайн салбараар ойрын үед тэргүүлж байгаа Хойт Америк болон Австралийн дараа 66 орноос 33-т орж байжээ.

Дэлхийн зах зээл дээрх түүхийн эдийн үнийн хэт өсөлт болон түүнээс бий болсон төсвийн орлогын гэнэтийн өсөлтөөс үүдэн эрдэс баялагийн салбар дахь улс төрийн популизм бий болж салбарын бодлогод сөргөөр нөлөөлж эхэлсэн. Үүний үр дүнд уул уурхай, эрдэс баялагийн салбарын хууль эрх зүйн орчин сул бөгөөд тогтворгүй болж эхэлсэн байна.

1997 оноос мөрдөгдөн хамгийн либерал хуулиудын нэгд тооцогдож байсан уул уурхай, эрдэс баялагийн салбарын гол хууль болох Ашигт малтмалын тухай хуулинд 2006 оны 6-р сард Монголын Парламент зарим өөрчлөлтүүдийг оруулсан. Уг хуулийн өөрчлөлтүүд нь стратегийн орд болон стратегийн ордонд хамаарах уул уурхайн төсөл дэх төрийн оролцоо бөгөөд энэ нь уг салбар дах тодорхойгүй байдал болон боломжит хөрөнгө оруулагчдыг алдах аюулыг өсгөөд байна. 1997 оны Ашигт малтмалын тухай хуулийн өөрчлөлтүүд болон алт зэсний салбарт хамааралтай шинээр гаргасан татварын хууль зэргээс болж Фрейзерийн Хүрээлэнгийн Уул уурхайн судалгаанд Монголын эзлэх байр 2006 болон 2007 онуудад огцом ухарч 68 орноос 61-т орсон. Энэ нь мөн уул уурхайн хөрөнгө оруулагчдын Монгол дах боломжийг муутгасан юм. Гэвч 2009 онд Монголын засгийн газар болон Айвенхо-Майнз хоёрын хооронд Оюу Толгойн алт-зэсний хөрөнгө оруулалтын гэрээ хийгдснээр эрдэс баялагийн эрх зүйн орчинд зарим зэрэг өөрчлөлтүүд гарсан.

Тухайлбал 2006 оны Эрдэс баялагийн тухай хуулинд нэмэлт өөрчлөлт оруулахаар гэрээний өмнө олон удаагийн ярилцлага хэлэлцүүлэг явуулсан. Бүр цаашдаа Гэнэтийн ашгийн татварын тухай хуулийг 2011 оны 1-р сараас эхлэн хүчингүй болгохоор тогтсон.

Өнгөрсөн жил судалгаанд оролцогчдын бараг тал орчим хувь нь уул уурхайн өнөөгийн хууль эрх зүйн орчин хувийн хөрөнгө оруулалтыг маш их хэмжээгээр үргээж байна гэсэн бол энэ жил уг хувь хэмжээ бараг 2 дахин буурч 23 хувьд хүрсэн байна. Гайхалтай нь, судалгаанд оролцогч уул уурхайн хөрөнгө оруулагчдаас уул уурхайн хууль болон зохицуулалтын орчин уг салбар дах

хувийн хөрөнгө оруулалтыг дэмжиж байна гэж үзэх хэсэг 6 хувиас 24 хувьд хүрч нилээд огцом өсчээ.

3. Татварын ерөнхий түвшин

Уул уурхайн салбарт хөрөнгө оруулалт хийх шийдвэр гаргахад хамгийн их чухал нөлөөлдөг хүчин зүйл бол татварын түвшин юм. Мэдээж цэвэр ашгаа максимумчилж байгаа бизнес нь хэрэгжүүлэх шийдвэртэй нийт татварын түвшинг авч үзэж, хүсч буй уул уурхайн үйлдвэрээ байгуулах эсэхээ шийдэхдээ татварын харьцуулсан шинжилгээг хийдэг болно. Янз бүрийн татвар, хураамж, шимтгэлийг багтаасан нийт татварын хэт өндөр ерөнхий түвшин нь хөрөнгө оруулагчийн өнөөгийн цэвэр үнэ цэнийг бууруулж өгөөжийн дотоод хувийг багасгадаг. Эсрэгээрээ дэндүү бага татварын ерөнхий түвшин нь засгийн газарт очих байсан боломжит орлогыг бууруулдаг. Иймээс, хувийн хөрөнгө оруулалтыг татахад тухайн улсад хувийн хөрөнгө оруулагч болон Засгийн газрын ашиг сонирхолыг тэнцвэржүүлсэн татварын түвшин байх ёстой.

Уул уурхайн салбар дах өнөөгийн татварын байдлын талаарх хөрөнгө оруулагчдын үнэлгээг энэ жил мөн уг судалгаанд авч орууллаа. Үүнд гол албан татварууд, төлбөр, хураамжуудыг, тухайлбал аж ахуйн нэгжийн албан татвар, байгалийн нөөц ашигласны төлбөр, лиценз болон газрын төлбөр гэх мэт, багтаасан болно. Гэнэтийн ашгийн татварын тухай асуултыг харьцуулах нь утгагүй зүйл учраас бид Монгол дах татварын ерөнхий түвшинг хөрөнгө оруулагчдаас асуусан болно.

Татварын ерөнхий түвшний хувьд, сайн зүйл нь уул уурхайн хөрөнгө оруулагчид буюу асуулганд оролцогчдын тал хүрэхгүй хувь нь Монголын татварын ерөнхий түвшин өндөр эсвэл маш өндөр гэж үзсэн байна. Бид асуулганд оролцогчдын нилээд дийлэнх хэсэг нь гэнэтийн ашигийн татвараас болж Монголыг өрсөлдөх чадварыг хангахуйц татварын орчингүй гэж үзэх байх гэж таамаглаж байсан. Магадгүй гэнэтийн ашгийн татвар нь Монгол дах зөвхөн алт зэс үйлдвэрлэгчдэд хамаатай болохоор нийт татварын түвшиний талаар үнэлгээ бидний хүлээж байснаас өөр гарсан байж болно.

Ерөнхийдөө, уул уурхайн хөрөнгө оруулагчид нь жигдхэн дараах хоёр хэсэгт хуваагддаг байна: “Монголын уул уурхайн татварын бусад оронтой харьцуулахад адилхан болон бага” гэж үздэг нэг хэсэг, нөгөө хэсэг нь “Монголын уул уурхайн татварын түвшин бусад орноос өндөр эсвэл хэт өндөр” гэж үздэг. Өөрөөр хэлбэл, Зураг 11-д харуулснаар 2009 оны хариултын бүтэц 2008 онтой харьцуулахад өөрчлөгдөөгүй гэдгийг харуулна.

4. Дэд бүтцийн болон ажиллах хүчний хөгжил

Уул уурхайн салбарт төдийгүй нийт эдийн засагт дэд бүтцийн хөгжил нь хөрөнгө оруулалтыг татахад зайлгүй чухал шийдэх зүйл юм. Далайд гарцгүй, хүн ам нь маш их тархан суурьшсан Монгол улсын хувьд эдийн засгаа хөгжүүлэхэд дэд бүтэц нь нэгэн том сорилт юм. Монгол дах дэд бүтцэд улсын

болон хувийн хөрөнгө оруулалт маш ихээр хийгдэж байгаа хэдий ч бизнесийн таатай орчныг бий болгохуйц сайжруулах орон зай оршоор байна.

2008 онд асуулганд оролцогчдын 80 гаруй хувь нь Монголын тээврийн салбарын хөгжил маш муу байгаа нь уул уурхайн салбар дах боломжит хөрөнгө оруулалтыг маш ихээр бууруулж байна гэж мэдэгджээ. 10 оролцогч тутмын 7 нь Монголын эрчим хүчний нийлүүлэлтийн найдваргүй байдал нь Монголын уул уурхай эрдэс баялагийн салбарт хувийн хөрөнгө оруулалт хийхэд саад болж байна гэдгийг хүлээн зөвшөөрсөн байна. Харамсалтай нь өнөөг хүртэл хөрөнгө оруулагчдын мөн ижил хувь нь тээврийн болон эрчим хүчний салбар нь хувийн хөрөнгө оруулалтанд саад бологч хүчин зүйл гэж үзсээр байна. Тээврийн болон эрчим хүчний салбартай харьцуулахад, харилцаа холбооны салбар нь харьцангуй сайн хөгжсөн салбар тул хөрөнгө оруулагчдын 40-өөс илүү хувь нь Монгол дах харилцаа холбооны салбар нь уул уурхай эрдэс баялагийн салбар дах хөрөнгө оруулалтыг дэмжиж байна гэж үзсэн байхад уул уурхайн хөрөнгө оруулагчдын өчүүхэн бага хувь нь тус салбарыг нилээд хэмжээгээр хөрөнгө оруулалтанд саад болж байна гэж хариулсан байна.

Хэдийгээр 1970-аад оны сүүлч үеэс уул уурхайн салбар Монголын эдийн засгийн гол салбаруудын нэг болж, олон олон мэргэжилтэй боловсон хүчин мэргэжлийн сургалтын байгууллагуудын хөгжлийн нэгэн зэрэг бэлтгэгдсэн ч, тэдгээр сургалтын байгууллагуудын ихэнх нь уул уурхайн технологийн нилээд өөрчлөлтийн улмаас сургалтын хөтөлбөр болон багаж тоног төхөөрөмж дээр ажиллах тал дээр аль хэдийн хоцрогдсон билээ. 2000 оноос эхлэн Монгол улсын уул уурхайн салбар нь гадаадын хөрөнгө оруулалтыг их хэмжээгээр татаж чадсанаар тус салбар нь орчин үеийн техник технологийг оруулж ирэх бололцоотой болсон. Энэ нь Монголын хөдөлмөрийн захаас шинэ ур чадвартай ажилчин, мэргэжилтнүүдийг шаардаж байна.

Гэвч, Монголд уул уурхайн салбарыг хурдацтай хөгжүүлэхэд ур чадвартай ажиллах хүчин маш их хомс байна. Хөрөнгө оруулагчид бараг бүгд (90 гаруй хувь) Монголын хөдөлмөрийн захаас шаардлага хангасан ажиллах хүчин, ажилчинг олоход хэцүү байдаг гэж мэдэгдсэн байна. Тодруулбал, 2008 онд 43 хувь нь шаардлага хангасан ажиллах хүчнийг олоход маш их хэцүү байдаг гэж үзсэн байхад, бараг тал орчим нь тохирсон ажиллах хүчнийг олоход бага зэрэг хүндрэлтэй нүүр тулгардаг гэжээ.

5. Хөрөнгө оруулалтын орчны бусад асуудлууд

Уул уурхайн салбарыг хөгжүүлэхэд геологийн тоо мэдээллийн хүрэлцээ болон хүртээмжтэй байдал, чанар зэрэг нь маргашгүй чухал бааз суурь болдог. Монголд зурагзүйн болон геологийн судалгаа нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байна. Ашигт малтмалын хэрэг эрхлэх газрын мэдээлснээр геологийн судалгааны ажилд зориулагдсан засгийн газрын төсөв

өссөн мэдээтэй байна. 2007 онд энэ нь 1999 оныхтай харьцуулахад хоёр дахин өссөн байна (880 сая төгрөгөөс 2.5 тэрбум төгрөгт хүрсэн).

Өнөөгийн байдлаар Монгол улсын нийт газар нутаг 1:200000 масштабтай геологийн зураглалд хамрагдсан бол газар нутгийн дөнгөж 22 хувь нь 1:50000 масштабтай зураглалд хамрагдаад байна.

Бид хөрөнгө оруулагчдаас Монгол дах геологийн тоон мэдээний ашиглалт, чанар болон хүртээмжтэй байдал зэргийн талаарх үнэлгээг асуусан. 2008 онд судалгаанд оролцогчдын гуравны нэгээс илүү хэсэг нь геологийн тоон мэдээний ашиглалт, чанар болон хүртээмжтэй байдал нь уул уурхайн хөрөнгө оруулалтыг дэмждэг гэсэн байхад бараг гуравны нэг нь уг салбар дах хувийн хөрөнгө оруулалтанд багахан хэмжээгээр саад болдог гэж боддог байна. 2009 онд эдгээр хувиудын өөрчөлт нь өндөр байгаагүй байна. Хоёр жилийн судалгаагаар геологийн тоо мэдээг бага хэмжээгээр саад болдог гэж үзсэн хариулагчдын хувь харьцангуй бага байна.

Уул уурхайн бизнесийн орчныг тодорхойлдог бусад шийдвэрлэх ач холбогдолтой хүчин зүйлсэд байгаль орчны зохицуулалтууд, аюулгүй байдал болон орон нутгийн иргэдийн харилцаа зэргийг авч үздэг. Тухайн улсын уул уурхайн салбарт хөрөнгө оруулах эсэхийг шийдэхэд аюулгүй байдал болон орон нутгийн иргэдийн харилцаа мөн чухал хүчин зүйл болдог.

Бид судалгаанд оролцогч уул уурхайн хөрөнгө оруулагчид болон уг салбарт үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудаас Монгол дах байгаль орчны зохицуулалтууд, орон нутгийн иргэдийн харилцаа болон үйл ажиллагааны аюулгүй байдлын талаарх үнэлгээг асуусан. Уул уурхайн хөрөнгө оруулагчдын гуравны нэгээс илүүтэй хэсэг нь Монголын өнөөгийн байгаль орчны зохицуулалт нь уг салбар дах хөрөнгө оруулалтыг дэмжиж байна гэж үнэлсэн бөгөөд тус хувь хэмжээ 2009 онд 21 хувьд хүрч буурчээ.

Өнгөрсөн жил судалгаанд оролцогчдын 40 гаруй хувь нь өнөөгийн үйлчилж буй байгаль орчны зохицуулалтууд нь хувийн хөрөнгө оруулалтанд саад болж байна гэж мэдэгдсэн бол 2009 онд уг хувь 60 гаруй хувьд хүрч мэдэгдэхүйц өндөр түвшинд хүрсэн байна. Аюулгүй байдлын хувьд уул уурхайн хөрөнгө оруулагчид болон байгууллагуудын дийлэнх хэсэг нь Монголд аюулгүй байдал хангалтай түвшинд байхгүй бөгөөд энэ 2008 оны хувьд Монгол дах хөрөнгө оруулалтанд их бага хэмжээгээр саад болсон гэж үзсэн байна.

Энэ жилийн хувьд уг хувь хэмжээ өөрчлөгдсөнгүй. Мөн орон нутгийн харилцаа нь хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад сөргөөр нөлөөлж болзошгүй төвөгтэй хүчин зүйлүүдийн нэгд зайлшгүй тооцогдож байна. Зураг 15-д харуулснаар өнгөрсөн хоёр жилийн туршид уул уурхайн хөрөнгө оруулагчдын 80 орчим хувь нь Монгол дах орон нутгийн иргэдийн харилцаа нь уул уурхайн хөрөнгө

оруулалтанд саад болж байна гэж үнэлсэн байна. Мэдээж орон нутгийн иргэдэд тухайн бүс нугаг дах уул уурхайн үйл ажиллагааг эсэргүүцэх олон шалтгаан байна. Үүнд: уул уурхайн аж ахуйн нэгжүүдийн үйлдвэрлэлийн муу удирдлагаас үүдэлтэй байгаль орчны стандартуудыг мөрдөхгүй, хууль журам зөрчих явдал, нөгөө талаар орон нутгийн иргэдийн уул уурхайн үйлдвэрийн орчин үеийн технологи болон үр ашгийн талаарх мэдлэг мэдээлэл муу байх зэргээс болж байна.

6. Уул уурхайн Хөрөнгө оруулалтын Өрсөлдөх чадварын (MIC) Индекс

Уул уурхайн хөрөнгө оруулалтын орчныг тодорхойлогч дээр дурьдагдсан гол хүчин зүйлүүдийн талаарх уул уурхайн хөрөнгө оруулагчдын үнэлгээнд тулгуурлан бид Монгол улсын уул уурхайн хөрөнгө оруулалтын өрсөлдөх чадварын индексийг тооцсон. Уул уурхайн хөрөнгө оруулалтын өрсөлдөх чадварын индекс нь нийлмэл индекс бөгөөд уул уурхайн хөрөнгө оруулалтын 15 гол шалгуурыг нэгтгэдэг бөгөөд эдгээр шалгуур үзүүлэлтүүдийг 5 бүлэгт хуваасан:

(a) Нийт эдийн засгийн болон улс төрийн орчин, (b) институтын чанар болон засгийн газрын үр бүтээлтэй байдал, (c) Татварын ерөнхий түвшин, (d) Дэд бүтцийн, хөдөлмөрийн зах зээлийн хөгжил, (e) Байгаль орчны зохицуулалтууд, орон нутгийн иргэдийн харилцаа болон аюулгүй байдлын асуудлууд.

Хүснэгт 2. Уул уурхайн Хөрөнгө оруулалтын Өрсөлдөх чадварын (MIC) Индекс

2009	Туслах индексүүд	2008	2009	2009/2008
1	Дэд бүтцийн хөгжил: Харилцаа холбоо	0.571	0.706	23.5%
2	Улс төрийн орчин	0.335	0.517	54.4%
3	Ерөнхий татварын түвшин	0.513	0.496	-3.2%
4	Нийт эдийн засгийн орчин	0.360	0.472	31.0%
5	Геологийн тоо өгөгдлийн чанар болон боломжтой байдал	0.559	0.467	-16.3%
6	Аюулгүй байдал	0.462	0.439	-5.0%
7	Институтын чанар болон үр ашигт байдал	0.219	0.422	92.1%
8	Байгаль орчны зохицуулалтууд	0.549	0.408	-25.7%
9	Эрдэс баялагийн хуулийн орчны тогтвортой, найдвартай байдал	0.191	0.388	102.6%
10	Орон нутгийн харилцаа	0.277	0.340	22.8%
11	Дэд бүтцийн хөгжил: Эрчим хүч	0.321	0.332	3.4%
12	Зохицуулалтын хэрэгжүүлэлт болон хяналтууд	0.195	0.311	59.5%
13	Дэд бүтцийн хөгжил: Зам	0.281	0.290	3.4%
14	Ур чадвартай ажиллах хүчний боломж	0.204	0.278	36.4%
15	Эдийн засаг дах засгийн газрын оролцоо	0.204	0.268	31.5%
MIC Ерөнхий Индекс		0.349	0.409	

Дүгнэлт

Хамгийн их утга нь 1 байх МИС ерөнхий индекс Монголын уул уурхайн салбарт 0.41 гэж тооцогдож байгаа нь өмнөх жилээс (0.35) бага зэрэг өссөн байна. Ерөнхий индексийг бүрдүүлдэг туслах 15 индексүүдийн жагсаалтаас харахад эдийн засаг дах засгийн газрын оролцоо, мэргэжилтэй ажиллах хүчний болон дэд бүтцийн хөгжил (харилцаа холбоог оруулахгүйгээр), хуулийн хэрэгжилт зэрэг нь нилээд анхаарал татсан хамгийн чухал хэсэгт тооцогдож байна. Эдгээр үзүүлэлтүүдийн үнэлэгдсэн индекс хамгийн бага буюу 0.27-0.33-ын хооронд байна. Орон нутгийн харилцаа болон эрдэс баялагийн хууль эрх зүйн орчин зэрэг нь уул уурхай салбар дах хөрөнгө оруулалтын орчныг сайжруулахад анхаарах дараагийн чухал асуудлууд юм.

МИС Индексүүдээс харахад 2008 болон 2009 онуудын хооронд Ерөнхий индекс 0.06 пунктээр буюу 17.1%-иар буурсан болохыг харж болно. Энэхүү өсөлтийн дөрөвний гурваас илүүтэй хэсэг нь зөвхөн 4 үзүүлэлтийн дүн дэх өсөлтөөс гарч ирсэн байна. Тодруулбал, (1) эрдэс баялагийн хууль эрх зүйн орчны тогтвортой найдвартай байдал, (2) засаглалын чанар болон үр бүтээлтэй байдал, (3) хуулийн хэрэгжилт болон (4) улс төрийн төлөв байдал.

2008 онтой харьцуулахад, эрдэс баялагийн хууль болон зохицуулалтын орчин харьцангуй тогтвортой байсан мөн тодорхой хүрээнд сайжирсан гэж үзэж болох юм. Тухайлбал, Монгол улсын их хурал 2011 оны 1-р сараас эхлэн гэнэтийн ашигийн татварыг хүчингүй болгох хуулийг¹ батлан гаргаад байна. Үүний үр дүнд өнгөрсөн оноос харьцангуй цөөн хөрөнгө оруулагчид Монголын эрдэс баялагийн хууль эрх зүйн орчны тогтвортой болон найдвартай байдлын талаар гомдоллосон байна.

Хэдийгээр Монгол улс дахь засаглалын чанар үр ашигт байдалд тодорхой хэмжээнд сайжирсан нь илт харагдахгүй байгаа ч, уг үзүүлэлтийн үнэлсэн оноо нь нилээд өссөн (0.219 - 0.422) дүнтэй байна. 2008 онд асуулганд оролцогчдын бараг 90 орчим хувь нь муу институтууд болон үр ашиггүй засаглал нь тодорхой хэмжээгээр Монголын уул уурхайн салбарт хувийн хөрөнгө оруулалт хийхэд саад болж байна гэж хариулсан байхад 2009 онд гуравны хоёр нь л дээрх хариултыг өгсөн байна. Цаашилбал, өнгөрсөн жил асуулганд оролцогчдын дөнгөж 6 хувь өнөөгийн засаглалын чанар уг салбар дах хөрөнгө оруулалтыг дэмжиж байна гэж хэлсэн бол энэ жил уг хариулт бараг 25 хувьд хүрч өссөн нь хөрөнгө оруулалтын тухайн шалгуур үзүүлэлтийн оноог өндөр болгоход нөлөөлсөн байна.

¹ Хөрөнгө оруулалтын орчныг муутгаж нилээд саад болж буй гэж тооцогддог “Гэнэтийн ашгийн татварын тухай хууль” нь 2006 онд батлагдсан.

Судалгаанд оролцогч уул уурхайн хөрөнгө оруулагчдын ойлголтоор бол, Монгол дах хуулийн даган мөрдөлт (хуулийн болон зохицуулалтуудийн хэрэгжүүлэлт, хяналт удирдлага) дээшилсэн бөгөөд үүнээс улбаалан уул уурхайн салбар дах хувийн хөрөнгө оруулалтанд сөрөг нөлөөлдөг гэсэн хэсэг багассан байна. Хуулийн хэрэгжилтийн индексийн үнэлгээний утга 0.195- 0.311 болж өссөнийг уул уурхайн салбар дах хувийн хөрөнгө оруулалтанд саад болдог гэж үздэг судалгаанд оролцогчид 48%-аас 26% болж буурсан гэдгээр тодорхой хэмжээнд тайлбарлаж байна. Мөн Монголын уул уурхайн хөрөнгө оруулалтыг хуулийн сахин мөрдөлт хэрэгжилт дэмжиж байна гэдэгтэй санал нийлэх уул уурхайн хөрөнгө оруулагчдын хэсэг 8%-аас 16% болж өссөн нь тухайн индексийн үнэлгээний утгыг өсгөхөд нөлөөлжээ.

Монголын улс төрийн нөхцөл байдал муудсан гэж үзэх хэсэг 40%-аас 22% болж буурсан нь улс төрийн орчны индексийн үнэлгээний утгыг 0.335-аас 0.517 болгож өсгөсөн. Нөгөө талаар улс төрийн орчныг сайжирсан гэж хариулсан уул уурхайн хөрөнгө оруулагчдын хэсэг нь 6%-аас 25% болж өссөн нь уг үнэлгээний утгыг өсгөхөд нөлөөлсөн.

Дээр дурьдагдсан уул уурхайн хөрөнгө оруулалтын орчны индексийн өсөлтийн дийлэнх хэсгийг бий болгосон үзүүлэлтүүдийн зэрэгцээ “мэргэжилтэй ажиллах хүчний бэлэн байдал, чанар”, “эдийн засаг дах засгийн газрын оролцоо”, “эдийн засгийн төлөв байдал”, “харилцаа холбооны хөгжил” болон “орон нутгийн иргэдийн харилцаа” зэрэг индексүүдийн үнэлсэн утгууд 23-36 хувиар өссөн. Гэвч зарим үзүүлэлтүүд өөрчлөгдөөгүй эсвэл бүүр өнгөрсөн хугацаанд буурсан дүнтэй гарсан байна. Тухайлбал уул уурхайн хөрөнгө оруулагчид өнөөг хүртэл Монгол дах дэд бүтэц, ялангуяа зам тээврийн хөгжил болон эрчим хүчний хангамжийг анхааруулсаар байна. Иймээс, холбогдох утгууд 2008 оныхаас бага гарсан байна. Энэ нь хөрөнгө оруулагчдын зүгээс Монгол улсын төр засаг уул уурхайн хөрөнгө оруулалтын орчныг сайжруулж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхийн тулд дэд бүтэц ялангуяа зам тээвэр, эрчим хүч, мэргэжилтэй ажиллах хүчний хангамж, хүрэлцээ, хуулийн хэрэгжилтийг сайжруулахыг хүсч байна.

Ном зүй

[1] Fraser Institute (2008), Annual survey of mining companies, Vancouver, BC, Canada.

[2] Metals Economics Group, Global Exploration Expenditures, Reports 2004-2008.

[3] Otto, James (2007). Competitive position of Mongolia’s mineral sector fiscal system: The case of a Model Copper Mine, *unpublished manuscript*. Boulder, CO, USA.

[4] The Behre Dolbear Group (2008), 2009 Ranking of countries for mining investment: Where “Not to Invest”, *Annual Report*, Denver, CO, USA.